



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай**

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай 2019 оны 229 дүгээр тогтоолын хавсралтын 9 дэх хэсгийг хассугай.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

ᠪᠣᠰᠣᠰᠢ